



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/213-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: ЦЭСБ-Аудит ХХК Утас: 95112689 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
 - 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитын
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЗГ	Засгийн газар
ТӨЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ШААМАР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.ӨСӨХЖАРГАЛ
ТАНАА

2023.02.25 № СХА-2023/213-НА-СА-ТЧЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шаамар сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Шаамар сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 86.3 хувьтай тайлагнагдсан бөгөөд цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон НДШ-ийн зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг тус тус хэмнэснээс голлон шалтгаалж, батлагдсан төсвийг 13.7 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

Шаамар сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 72,8 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал тус тус эзэлж байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	129,452,141.58	261,436,640.51
31	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	-	139,854,247.88
311	Кассанд байгаа	-	
312	Банкинд байгаа		139,854,247.88
33	АВЛАГА	-	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		
35	БАРАА МАТЕРИАЛ	129,452,141.58	121,582,392.63
351	Түүхий эд материал	14,068,526.76	14,201,390.26
35110	Тусгай зориулалттай материал	13,986,526.76	14,134,390.26
35130	Эм боох материал	30,000.00	30,000.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		
35300	Бэлэн бүтээгдэхүүн	52,000.00	37,000.00
354	Хангамжийн материал	115,383,614.82	107,381,002.37
35410	Бичиг хэргийн материал	288,700.00	33,300.00
35420	Аж ахуйн материал	58,101,050.10	49,010,447.65
35430	Сэлбэг хэрэгсэл	370,000.00	4,592,900.00
35440	Түлш шатах тослох материал		
35450	Барилгын засварын материал	6,853,000.00	6,853,000.00
35460	Хүнсний материал	697,880.00	773,150.00
35470	Бусад хангамжийн материал	46,430,704.72	46,118,204.72
356	Мал амьтад	2,642,280.00	
36	НӨӨЦИЙН БАРАА		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,263,075,214.54	2,410,330,635.32
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,263,075,214.54	2,410,330,635.32
392	Биет хөрөнгийн дүн	2,228,752,093.33	2,375,090,761.86
39201	Барилга байгууламж	2,030,135,596.00	2,030,135,596.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(152,346,000.08)	(51,477,307.92)
39217	Тээврийн хэрэгсэл	14,562,500.00	14,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(606,770.83)	(7,281,249.96)
39205	Машин тоног төхөөрөмж	255,845,662.65	272,333,306.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	(60,760,678.00)	(77,163,142.51)
39207	Тавилга, эд хогшил	117,550,600.12	127,978,765.02
39208	Хуримтлагдсан элэгдэл	(53,035,751.38)	(15,138,942.39)
39213	Түүх соёлын дурсгалт зүйлс		
39214	Бусад үндсэн хөрөнгө	65,007,018.00	65,007,018.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(9,004,953.63)	(8,921,889.36)
39217	Ном	21,404,870.48	25,056,108.97
393	Биет бус хөрөнгийн дүн	34,323,121.21	35,239,873.46
39301	Программ хангамж	6,001,027.55	6,001,027.55
39302	Хасагдуулга	(1,941,906.34)	(1,025,154.09)
39302	Бусад хөрөнгө	30,264,000.00	30,264,000.00
39303	Хөрөнгө оруулалтын зориулалттай ҮХХ		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,392,527,356.12	2,671,767,275.83
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41361	Байгууллагад төлөх өглөг		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,392,527,356.12	2,671,767,275.83
51	Засгийн газрын хувь оролцоо	2,392,527,356.12	2,671,767,275.83
511	Засгийн газрын оруулсан капитал	756,321,843.72	756,321,843.72
51101	Өмч: -төрийн	756,321,843.72	756,321,843.72
512	Хуримтлагдсан үр дүн	26,501,467.94	305,741,387.65
51210	Өмнөх үеийн үр дүн	30,921,175.25	(2,366,025,888.18)
51220	Тайлант үеийн үр дүн	(4,419,707.31)	2,671,767,275.83
51300	Дахин үнэлгээний зөрүү	1,609,704,044.46	1,609,704,044.46
6	ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН	2,392,527,356.12	2,671,767,275.83

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	847,397,121.38	3,694,753,794.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	748,923,751.38	2,676,062,453.34
120	Нийтлэг татварын бус орлого	159,701,951.38	2,676,062,453.34
120002	Хүүгийн орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	159,701,951.38	2,538,649,361.51
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		2,502,900.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	128,531,356.76	2,536,146,461.51
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	31,170,594.62	137,413,091.83
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	589,221,800.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	589,221,800.00	
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	98,473,370.00	1,018,691,341.26
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	867,701,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		867,701,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,600,670.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,600,670.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	89,872,700.00	150,990,041.26
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	89,872,700.00	150,990,041.26
2	Үйл ажиллагааны зардал	851,816,828.69	1,022,986,518.77
21	Урсгал зардал	851,816,828.69	1,022,986,518.77
210	Бараа, үйлчилгээний зардал	816,244,016.98	986,172,018.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	519,018,061.36	710,893,968.50
210101	Үндсэн цалин	368,387,440.36	432,039,118.91
210102	Нэмэгдэл цалин	123,794,721.00	258,806,219.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	26,835,900.00	20,048,630.00
210105	Гэрээтийн цалин		
2102	Нийгмийн даатгалын шимтгэл	57,084,073.92	72,869,803.48
210201	Тэтгэврийн даатгалын	39,870,725.21	53,052,740.32
210202	тэтгэмжийн даатгалын	5,232,078.55	5,110,023.59
210203	ҮОМШӨ-ий даатгалын	3,230,010.19	4,087,725.90
210204	Ажилгүйдлийн даатгалын	796,141.17	956,874.18
210205	ЭМ-ийн даатгалын	7,955,118.80	9,662,439.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,848,400.00	106,190,126.79
210301	Гэрэл цахилгааны зардал	5,250,500.00	8,123,910.00
210302	Түлш, халаалтын зардал	80,189,900.00	95,066,216.79
210303	Цэвэр бохир усны зардал	1,408,000.00	3,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,974,100.00	-
210401	Бичиг хэргийн зардал	485,600.00	
210404	Тээвэр шатахуун	800,000.00	

210403	Шуудан, холбоо, интернэтийн зардал	1,114,600.00	
210404	Ном, хэвлэл	258,600.00	
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	143,000.00	
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал	1,189,600.00	
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	394,900.00	
210408	Бараа материал акталсны зардал	3,587,800.00	
2105	Нормативт зардал	13,822,815.00	27,138,570.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	515,400.00	
210502	Хоол, хүнс	12,796,915.00	27,138,570.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	510,500.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,504,700.00	5,444,950.00
210601	Багаж техник, хэрэгсэл	4,500,000.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл		
210604	Урсгал засварын зардал	4,004,700.00	5,444,950.00
2107	Томилолтын зардал	193,000.00	-
210702	Дотоодын томилолт	193,000.00	
210703	Гадаадын томилолт		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	1,605,200.00	6,236,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	957,200.00	
210802	Аудит баталгаажуулалтын зардал	648,000.00	
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ		6,236,500.00
2109	Бараа, үйлчилгээний бусад зардал	121,193,666.70	57,398,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		48,013,600.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	1,809,700.00	9,384,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	119,383,966.70	
213	Урсгал шилжүүлэг	35,572,811.71	36,814,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,309,580.00	36,814,500.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	15,909,580.00	36,814,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,400,000.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	18,263,231.71	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,263,231.71	
3	Үйл ажиллагааны үр дүн	(4,419,707.31)	2,671,767,275.83
145	Үйл ажиллагааны бус орлогын дүн		
225	Үйл ажиллагааны бус зардлын дүн		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		
4	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
5	Үйл ажиллагааны нийт үр дүн	(4,419,707.31)	2,671,767,275.83

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	687,695,170.00	1,021,194,241.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	589,221,800.00	2,502,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	2,502,900.00
120002	Хүүгийн орлого		
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	2,502,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		2,502,900.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	589,221,800.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	589,221,800.00	
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	98,473,370.00	1,018,691,341.26
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	867,701,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		867,701,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,600,670.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,600,670.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	89,872,700.00	150,990,041.26
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	89,872,700.00	150,990,041.26
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	681,122,170.00	851,325,993.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	681,122,170.00	851,325,993.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	645,549,358.29	814,511,493.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	473,036,895.37	569,247,443.11
210101	Үндсэн цалин	322,406,274.37	432,039,118.91
210102	Нэмэгдэл	123,794,721.00	117,159,694.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	26,835,900.00	20,048,630.00
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,505,547.92	72,869,803.48
210201	Тэтгэврийн даатгалын	40,157,328.21	53,052,740.32
210202	Тэтгэмжийн даатгалын	5,265,796.55	5,110,023.59
210203	ҮОМШӨ-ий даатгалын	3,236,754.19	4,087,725.90

210204	Ажилгүйдлийн даатгалын	863,577.17	956,874.18
210205	Эрүүл мэндийн даатгалын	7,982,091.80	9,662,439.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,848,400.00	106,190,126.79
210301	Гэрэл цахилгааны зардал	5,250,500.00	8,123,910.00
210302	Түлш, халаалтын зардал	80,189,900.00	95,066,216.79
210303	Цэвэр бохир усны зардал	1,408,000.00	3,000,000.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материал	4,270,800.00	-
210401	Бичиг хэргийн зардал	699,600.00	
210404	Тээвэр шатахуун	800,000.00	
210403	Шуудан холбооны зардал, мэдээлэл тех-гийн үйлчилгээ	1,114,600.00	
210404	Ном	33,300.00	
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	433,700.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,189,600.00	
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	13,822,815.00	27,138,570.00
210501	Эм	515,400.00	
210502	Хоол, хүнс	12,796,915.00	27,138,570.00
210503	Нормын хувцас	510,500.00	
2106	Эд хогшил урсгал засвар	4,107,000.00	5,444,950.00
210601	Багаж техник хэрэгсэл	102,300.00	
210604	Урсгал засвар	4,004,700.00	5,444,950.00
2107	Томилолт, зочны зардал	193,000.00	-
210702	Дотоодын томилолт	193,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	3,955,200.00	6,236,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,307,200.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ		6,236,500.00
210807	Газрын төлбөр		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,809,700.00	27,384,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		17,999,600.00

210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	1,809,700.00	9,384,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,572,811.71	36,814,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,309,580.00	36,814,500.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	15,909,580.00	36,814,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,400,000.00	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэлт	18,263,231.71	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,263,231.71	
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	6,573,000.00	169,868,247.88
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
4	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн	-	-
22	Хөрөнгийн зардал	-	(30,014,000.00)
2200	Дотоод эх үүсвэрээр	-	(30,014,000.00)
	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		(30,014,000.00)
222001	Тоног төхөөрөмж		
223001	Бусад хөрөнгө		
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	(30,014,000.00)
7	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх		
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	6,573,000.00	139,854,247.88
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		139,854,247.88

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
А	1	2	3	4
2020 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	756,321,843.72	1,609,704,044.46	30,921,175.25	2,396,947,063.43
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			(4,419,707.31)	(4,419,707.31)
2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	756,321,843.72	1,609,704,044.46	26,501,467.94	2,392,527,356.12
НББ-ийн бодлогын өөрчлөлт			(2,392,527,356.12)	(2,392,527,356.12)
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			2,671,767,275.83	2,671,767,275.83
2022 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	756,321,843.72	1,609,704,044.46	305,741,387.65	2,671,767,275.83

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,021,194,241.26	881,339,993.38	139,854,247.88	86.3
21	Урсгал зардлын дүн	1,021,194,241.26	881,339,993.38	139,854,247.88	86.3
210	Бараа үйлчилгээний зардал	1,021,194,241.26	881,339,993.38	139,854,247.88	86.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	680,484,085.00	569,247,443.11	111,236,641.89	83.7
210101	Үндсэн цалин	524,963,472.00	432,039,118.91	92,924,353.09	82.3
210102	Нэмэгдэл	142,242,613.00	117,159,694.20	25,082,918.80	82.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	0	-	
210104	Урамшуулал	13,278,000.00	20,048,630.00	(6,770,630.00)	151.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,844,529.47	72,869,803.48	8,974,725.99	89.0
210201	Тэтгэврийн даатгал	57,656,290.07	53,052,740.32	4,603,549.75	92.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,782,622.35	5,110,023.59	1,672,598.76	75.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,426,017.85	4,087,725.90	1,338,291.95	75.3
210204	Ажилгүйдлийн даатгал	1,356,504.50	956,874.18	399,630.32	70.5
210205	ЭМД-ын хураамж+В21	10,623,094.70	9,662,439.49	960,655.21	91.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	111,635,076.79	106,190,126.79	5,444,950.00	95.1
210301	Гэрэл цахилгааны зардал	8,123,910.00	8,123,910.00	-	0.0
210302	Түлш, халаалтын зардал	95,066,216.79	95,066,216.79	-	0.0
210303	Цэвэр бохир усны зардал	3,000,000.00	3,000,000.00	-	0.0
210304	Байрны түрээсийн зардал	5,444,950.00		5,444,950.00	0.0
2105	Нормативт зардал	32,296,300.00	27,138,570.00	5,157,730.00	84.0
210501	Эм	-	-	-	0.0
210502	Хоол хүнс	32,296,300.00	27,138,570.00	5,157,730.00	84.0
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	-	-	-	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,444,950.00	5,444,950.00	-	100.0
210604	Урсгал засвар	5,444,950.00	5,444,950.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	6,256,300.00	6,236,500.00	19,800.00	99.7
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	6,256,300.00	6,236,500.00	19,800.00	99.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,398,100.00	57,398,100.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,013,600.00	48,013,600.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,384,500.00	9,384,500.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг			-	
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж			-	

213205	Төсвөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	45,834,900.00	36,814,500.00	9,020,400.00	80.3
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,021,194,241.26	1,163,551,389.14	(142,357,147.88)	113.9
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	870,204,200.00	870,204,200.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	870,204,200.00	870,204,200.00	-	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих			-	
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	150,990,041.26	150,990,041.26	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	150,990,041.26	150,990,041.26	-	0.00
134	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	142,357,147.88	(142,357,147.88)	
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих			-	
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос		2,502,900.00	(2,502,900.00)	
	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл			-	
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		139,854,247.88	(139,854,247.88)	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын сургууль нь “Хүүхдийн хөгжлийг тасралтгүй дэмжиж, хичээл сургалтын үйл ажиллагааг хосолсон хэлбэрээр үр дүнтэй зохион байгуулж хоцрогдлыг нөхөх, арилгахад бүх талын оролцоог дэмжин ажиллах” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Суралцагч бүрийг боловсролд тэгш хамруулах, сургууль завсардахаас сэргийлэх, “Ногоон гэрэл” хөтөлбөрийг үр дүнтэй хүртээмжтэй хэрэгжүүлэх
- Хичээл, сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангаж цахим хичээлийн болон даалгаврын сан бүрдүүлэн ашиглах
- Багш, удирдах ажилтан бүр сургалтын арга хэлбэрийг оновчтой сонгон, заах арга зүй, мэдлэг ур чадвараа хөгжүүлж, ажлын байрандаа тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх
- Суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлээ зөв сонгоход дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн зорилтот арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэх
- Мэргэжил, арга зүйн байгууллага болон мэргэжлийн бүлгээр хамтран ажиллаж, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгахад дэмжлэг үзүүлэн сургалт үйл ажиллагааны чанарыг сайжруулах
- Ажлын байран дээрх эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг бэхжүүлэх
- Багш, ажилтны хөдөлмөрийг бодитой үнэлж, шагнаж урамшуулах, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- Боловсролын тухай хуульд 2022 онд 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон,
- ЗГ-ын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” журам хэрэгжиж эхэлсэн,
- ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоолын 5, 6 дугаар хавсралтаар батлагдсан “Шинжлэх ухааны байгууллага, сургуулийн өмнөх болон бага, дунд

боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ батлах тухай ” тогтоолд 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,

- ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох” тогтоолд 2022 оны 252 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалаар батлагдсан “Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг хэрэгжүүлж эхэлсэн,
- БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуульд, кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”-ыг шинэчлэн баталсан,
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” хэрэгжиж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шаамар сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсны хувьд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/202 тоот захирамжаар баталсан. Сэлэнгэ аймгийн ТЭЗ-ийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тайлант онд мөрдөж ирсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шаамар сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 279,239.9 мянган төгрөгөөр буюу 11.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	139,854.2	139,854.2
Авлага	-	-	
Бараа материал	129,452.1	121,582.4	(7,869.7)
Үндсэн хөрөнгө	2,263,075.2	2,410,330.6	147,255.4
Нийт хөрөнгө	2,392,527.3	2,671,767.2	279,239.9
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,392,527.3	2,671,767.2	279,239.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,392,527.3	2,671,767.2	279,239.9

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 139,854.2 мянган төгрөгийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 8.7-д “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ.” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 121,582.4 мянган төгрөг болж 7,869.7 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 87,702.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар БШУЯ-аас 929.1 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 1,700.5 мянган төгрөгийн аж ахуйн материал хүлээн авч бүртгэсэн бөгөөд үйл ажиллагаанд 86,724.8 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулж, үндсэн хөрөнгийн шинжтэй 11,477.4 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлснээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 2,540,771.3 мянган төгрөг болж 30,567.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 10,988.4 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 50.0 мянган төгрөгийн номыг худалдан авч, хандиваар БШУГ-аас 2,800.0 мянган төгрөгийн /хөргөгч/ машин тоног төхөөрөмж, сургуулийн төгсөгчдөөс 1,650.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, аймгийн БШУГ-аас 3,601.2 мянган төгрөгийн номыг тус тус үнэ төлбөргүй орлогоор бүртгэн, үндсэн хөрөнгийн шинжтэй 11,477.4 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалаас шилжүүлэн авснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,671,767.2 мянган төгрөг болж 279,239.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 947,860.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 121,545.3 мянган төгрөгөөр нийт зарлагыг 1,069,405.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд хийсэн төсвийн зохицуулалтаар цалин, НДШ-ийн зардлыг 48,211.6 мянган төгрөгөөр бууруулан нийт төсвийг 1,021,194.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 870,204.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 150,990.0 мянган төгрөг нийт 1,021,194.2 мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулахаар төлөвлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 881,339.9 мянган төгрөг буюу 86.3 хувьтай байгаа нь цалингийн зардлаас 111,236.6 мянган төгрөг, НДШ-ийн зардлаас 8,974.7 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 5,445.0 мянган төгрөг, норматив зардал 5,157.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил 19,9 мянган төгрөг, төсвөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал 9,020.4 мянган төгрөг нийт 139,854.3 мянган төгрөгийг хэмнэснээс шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл
/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
1	71802 Ерөнхий боловсрол	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	2,502,5	2,502.5	0	100
		2	80312- Сургалт семинар	1,251,3	1,251.3	0	100

3	81605- Эрүүл мэндийг дэмжих	2,877,9	2,877.9		100
4	81801- Үдийн цай хөтөлбөр	45,834,9	36,814.5	9,020.4	80,3
5	81807-Дотуур байрны хүүхдийн зардал	51,806.7	11,647.0	40,159.7	73,3
6	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	29,970,0	29,970,0	0	100
7	81823- Боловсролын багшийн сургалт	5,630,7	5,630.7	0	100
8	81834- Боловсролын стандарт сургалт	619,071.1	553,652.5	65,418.6	83,9
9	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	108,756.2	86,003.5	22,752.7	68,6
10	81848-Сурах бичгийн түрээс	2,502.9		2,502.9	
11	83602- ЗД нөөц хөрөнгөөс	0	0	0	
12	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	111,635.0	111,635.0	0	100
13	80112- Нийтлэг үйлчилгээ	39,355.0	39,355,0	0	100
Нийт		1,021,194.2	881,339.9	139,854.3	85,7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна.” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шаамар сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын санхүүгийн тайлантай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Э.Эрдэнэбат гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Шаамар сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ЦЭСБ-Аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 851,816.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 8,518.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Боловсролын ерөнхий газраас нийт боловсролын байгууллагуудад 2022 оны 04, 09 дүгээр саруудад төрийн хэмнэлтийн тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн үйл ажиллагааг цахимжуулах, бараа үйлчилгээний зардлыг бууруулах, зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Шаамар сумын ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Боловсролын салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлж батлагдсан орон тоогоор бус гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотойгоор цалин, ажил олгогчоос төлөх НДШ, үдийн цай хөтөлбөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр нийт 139,854.3 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь : Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг зөрчсөн тул холбогдох мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмж өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“ЦЭСБ-Аудит” ХХК-ийн 2022 оны 11 дүгээр 21-ний 227 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй 80,189.9 мянган төгрөгийн, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	80,189.9	2	75,934.4	55.0
Нийт дүн	2	80,189.9	2	75,934.4	55.0

Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь

хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудал нь тухайн төсвийн захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн учир Шаамар сумын ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчлөөр тооцоолгүйгээр дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан, хяналт тавьж байх шаардлагатай байна.
2. Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан “Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан” гэсэн зориулалтаар, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого / 120010 / ангиллаар гүйцэтгэхээр чиглэл хүргүүлсэн байна. Нэмэлтээр хуваарилах төсвийн эх үүсвэрийг төсвийн санхүүжилтийн эх үүсвэр болгон төлөвлөж байгаагаас гүйцэтгэлээр уг санхүүжилт хуваарилагдаагүй тохиолдолд төсвийн санхүүжилтийн төлөвлөгөө тасарснаар тайлагнагдах эрсдэлтэй байна. Иймд дээд шатны төсвөөс хуваарилах нэмэлт төсвийг төсвийн санхүүжилт хэлбэрээр урьдчилан төлөвлөж, батлалгүйгээр санхүүжилт ирсэн тухай бүр тухайн санхүүжилтийн дүнгээр зарцуулах эрх тавих нь зүйтэй юм.
3. Тус байгууллага нь өмнөх жилүүдэд тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсан учир Сэлэнгэ аймгийн ЗД-ын 2020 оны 7 дугаар сарын 16-ний өдрийн А/202 дугаар захирамжаар баталсан “Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ирсэн байна. Бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч боловсролын байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй учир төсвийн ерөнхийлөн захирагчийн боловсруулсан НБББББ-ыг мөрдөх нь зүйтэй юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй болно.

Аудитаар нийт 4,255.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 4,255.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

1 Албан шаардлага

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулж цахим системд шивэх талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс 4,255.5 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэх.

5.2. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

1. Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дахь “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 8.1.5 дахь “санхүүгийн тайлангийн тодруулга” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, онцлог байдлыг илтгэсэн тайлбар, тодруулгуудыг хийж байх.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төлбөрийн цахим баримт дутуу	1	4,255.5			1	4,255.5						
Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй	1						1					
Дүн	2	4,255.5			1	4,255.5						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
1 мэдээлэл хоцроосон	1						1	
Дүн	1					-	1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1						1	